



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 11 сарын 05 өдөр

Дугаар СХШ-2025/06

Сүхбаатар сум

Сэлэнгэ аймгийн Сэлэнгэ бүсийн сум
дундын ойн ангийн санхүүгийн үйл ажиллагаанд
хийсэн хяналт шалгалтын дүн

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1 Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан 2025 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн СХШ-2025/06/ТШЗ дугаартай “Санхүүгийн хяналтын ажлын удирдамж”-аар Сэлэнгэ бүсийн сум дундын ойн ангийн санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулан зөвлөх зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2 Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга СХШУАБ Т.Одсүрэн ахлан, дотоод аудитор Д.Ванчигмаа 2025 оны 11 дүгээр сарын 17-ний өдрөөс ажлын 20 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

1.3 Шалгалтаар Сэлэнгэ бүсийн сум дунд ойн ангийн 2024 он, 2025 оны 3-р дугаар улирлын санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4. Сэлэнгэ бүсийн сум дундын ойн ангийн нь улсын бүртгэлийн 3746704 дугаар регистртэй, Төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100130713002 дугаартай данс, нэмэлт санхүүжилтийн 100130713402 дугаартай дансуудыг ашиглаж байна.

1.5 Тус газрын Төсвийн орлого зарлага, тайлагналт, Төрийн сангийн харилцах дансанд 1-р гарын үсгийг Сэлэнгэ бүсийн сум дундын ойн ангийн дарга Н.Амаржаргал 2-р гарын үсгийг нягтлан бодогч Н.Цолмон нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулж байна.

1.6 Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2024 оны 02 сарын 15 өдрийн А/66 тоот захирамж 8 хүний орон тоо батлагдсанаас одоогийн байдлаар байгууллага нь дарга 1 ойн ахлах инженер 1, техникч 1, техникч нярав 1, нягтлан бодогч 1 гэсэн 5 оронтойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

4325001183

1.7 Сэлэнгэ аймгийн Цагааннуур сум дахь Сэлэнгэ бүсийн сум дундын Ойн анги нь Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ойн тухай хууль, Монгол Улсын Засгийн Газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Сэлэнгэ аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол улсын Ногоон хөгжлийн бодлого, Тэрбум мод үндэсний хөдөлгөөн зэрэг тогтоол, шийдвэр, дүрэм, стандартын хэрэгжилтийг бүс нутагт хэрэгжүүлэх, ойн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт, ойн хөнөөлт шавж, ойн хээрийн түймрийн нөлөөллөөс хамгаалах болон нөхөн сэргээх, зүй зохистой ашиглалтыг сумдын ИТХ, ЗДТГазартай хамтран төлөвлөн зохион байгуулах, иргэдэд экологийн боловсрол олгох, Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг бүс нутагт зохион байгуулах, зөвлөн туслах, мод үржүүлгийн газрын үйл ажиллагааг явуулж байна.

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 126-р тогтоолын дагуу 2013 оны 09-р сарын 16-ны өдөр Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Сэлэнгэ бэлчирийн бүсийн сум дундын ойн анги нь үүссэн байгуулагдсан бөгөөд 2018 оны 08-р сарын 02 өдрийн Сэлэнгэ бүсийн сум дундын ойн анги болж байгууллагын нэр өөрчлөгдсөн байна.

Сэлэнгэ бүсийн сум дундын ойн анги нь Зүүнбүрэн, Түшиг, Цагааннуур сумдын 284,088 га ойн сан бүхий талбайг хариуцан, сумдын ойн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ойн аж ахуйн арга хэмжээг бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ойн мэргэжлийн эрх бүхий 5 аж ахуйн нэгж болон ойн санг гэрээгээр эзэмшигч 40 ойн нөхөрлөлтэй (Түшиг 22, Зүүнбүрэн 13, Цагааннуур 5) хамтран хэрэгжүүлж байна.

Байгууллагын эрхэм зорилго: Бүсийн ойн санг зөв зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хангах зорилгоор мэргэжлийн өндөр түвшний, цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлж, иргэн, ойн санг гэрээгээр эзэмшигч ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийг бэхжүүлэн, үр ашигтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэн үйл ажиллагаа явуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Цагааннуур сумын ойн санд 6,000 га, Түшиг сумын ойн санд 6,000 га талбайд, мөн Цагааннуур сумын 2025 оны төсөв, БНАТ-ын хөрөнгөөр 1,000 га, Түшиг суманд 428 га талбайд тус тус ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажлыг Хатантпорест ХХК-ийн АН-2 агаарын хөлгөөр авиа микробиологийн аргаар 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрөөс 06 дугаар сарын 14-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн байна.

Үүний хүрээнд Цагааннуур сумын ойн хөнөөлт шавжийн голомт бүхий голын ай сав газрууд болох 1 дүгээр багийн Жаргалант, Товхан уул, Баянхонгорын овоо, Нарангийн давааны ар, Баян харын овоо, Их Бургастай, Хуурч, 2 дугаар багийн Их хүнгэ, Бага хүнгэ, Ганц мод, Хар модот, Далайн яст, Ноёны булаг, Цоорч, Хуурч зэрэг газруудад 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрөөс 06 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл, Түшиг сумын 1, 2 дугаар багийн нутаг дэвсгэрт хамрагдах Ар нуга, Хүйтний ам, Хужирт, Хуурай төгж, Номт, Сөрт, Хадан хошуу, Арван нарст, Атрын даваа, Шивээт, Хэрэгчин, Тавилан, Мэлзэн, Баяны хавтгай, Хар горхи, Ангийн отог,

Гурван ховил, Моностой, Улаалзганат, Бэлчир, Ухмал, Рашаант зэрэг газруудад 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс 06 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл тус тус хийж гүйцэтгэсэн байна. Жил бүрийн 03 дугаар сарын 21-ний өдөр тохиодог "Олон улсын Ойн өдөр", "Дэлхийн усны өдөр"-ийг тохиолдуулан 2025 оныг НҮБ-аас "Ой ба хүнс" уриа дор тэмдэглэхээр зарласантай холбогдуулан Монгол Улсын "Байгаль орчныг хамгаалах тухай хууль", "Ойн тухай хууль", Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх, сурталчлан таниулах, байгальд ээлтэй зөв иргэнийг төлөвшүүлэх, ойн мэргэжлийг олон нийтэд таниулах зорилгоор Сэлэнгэ бүсийн Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн сумдын ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын дунд "Байгаль хамгаалал – Бидний оролцоо 2025" дэвжээ тэмцээнийг 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан байна.

Ойжуулалт, нөхөн тарилт, мод тарилт, ногоон байгууламж

Аймгийн Засаг даргын "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр, 'Тэрбум мод' үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих өдрийг зохион байгуулах тухай" 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/226 дугаар захирамж, Атрын IV аяны хүрээнд Сэлэнгэ аймгийн Засаг дарга, Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, "Атартрейд" ХХК-ийн дэмжлэгтэйгээр Сэлэнгэ аймгийн Цагааннуур суманд 3 км тариалангийн талбайн хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлыг зохион байгуулсан байна.

Тус ажлын хүрээнд сумын Засаг даргын Тамгын газар, Сум дундын ойн анги, Цагааннуур тохижилт ОНӨААТҮГ-ын ажилтан, албан хаагчид хаврын мод тарилтын талбайг хашаажуулах, зурвас татах, 2,181 ширхэг мод тарих нүх, шуудуу ухах бэлтгэл ажлыг хийж, 2025 оны 05 дугаар сарын 08–09-ний өдрүүдэд 8 төрийн болон төсвийн байгууллагын 95 ажилтан, албан хаагч хамрагдан 1,200 ширхэг нарс мод тарьсан байна.

Мөн 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Сэлэнгэ бүсийн сум дундын ойн ангийн мод үржүүлгийн газраас бургас 261 ширхэг, улиас 312 ширхэг, монос 50 ширхэг, агч 348 ширхэг, хайлаас 10 ширхэг буюу нийт 981 ширхэг навчит модыг шилжүүлэн суулгаж, хамтран зохион байгуулан ажилласан байна.

Түүнчлэн нийтийн эзэмшлийн зам дагуух ногоон байгууламжийн хашаанд нөхөн тарилтаар 30 ширхэг нарс мод тарьж, иргэн, айл өрхүүд хашаандаа жимсний мод 250 ширхэг, навчит мод 130 ширхэг, шилмүүст мод 125 ширхэг тарьснаар сумын хэмжээнд нийт шилмүүст мод 1,055 ширхэг, навчит мод 1,111 ширхэг, жимсний мод 250 ширхэг буюу нийт 2,416 ширхэг мод тарьсан байна.

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

- 2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт**

Сэлэнгэ бүсийн сум дундын ойн анги нь санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг санхүү, бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байна

2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

2024 онд 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 176,725.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 89.4 хувь буюу 155,009.7 мянган төгрөгийг зарцуулж, 12.3 хувь буюу 12,135.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг ангиллаар нь харьцуулбал: цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлаас 11,600.5 мянган төгрөгийн, ажил олгогчийн НДШ-ийн зардлаас 1,652.1 мянган төгрөгийн, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 197.0 мянган төгрөгийн, хангамж бараа материалын зардал 1,475.7 мянган төгрөгийн урсгал засвар зардлаас 201.0 мянган төгрөгийн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардлаас 850.0 мянган төгрөгийн, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлаас 198.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй буюу хэмнэлттэй зарцуулсантай

Төсвийн гүйцэтгэлийг доорх хүснэгтээр харуулбал: /2024 он, 2025 оны 3 дугаар улирлын байдлаар/

Хүснэгт 1.

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	2024 оны жилийн эцэс		хэтрэлт хэмнэлт	Хувь	2025 оны 3 дугаар ул,		хэтрэлт хэмнэлт	Хувь
		Төлөвлөгөө	гүйцэтгэл			Төлөвлөгөө	гүйцэтгэл		
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	176,725.1	155,009.7	21,715.4	87.7	143,306.6	96,254.4	47,052.2	67.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	176,725.1	155,009.7	21,715.4	87.7	143,306.6	96,254.4	47,052.2	67.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	121,475.6	109,875.1	11,600.5	90.5	140,746.0	111,901.2	28,844.8	79.5
210101	Үндсэн цалин	66,787.3	77,028.6	(10,241.3)	115.3	60,955.0	76,751.1	(15,796.1)	126.0
210102	Нэмэгдэл	43,922.3	29,875.7	14,046.6	68.0	79,791.0	35,150.1	44,640.9	44.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,457.4	1,782.0	3,675.4	32.7				
210104	Урамшуулал	5,308.6	1,188.8	4,119.8	22.4				
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,713.5	14,061.4	1,652.2	89.5	17,593.1	13,765.4	3,827.7	78.2
210201	Тэтгэврийн даатгал	10,434.7	9,575.2	859.5	91.8	11,963.4	9,354.6	2,608.8	78.2
210202	Тэтгэмжийн даатгал	1,227.7	1,126.5	101.2	91.8	1,407.6	1,100.5	307.1	78.2

210203	ҮОМШӨ-ний даатгал	1,350.8	560.0	790.9	41.5	703.8	575.5	128.4	81.8
210204	Ажилгүйдлийн даатгал	245.3	560.0	(314.7)	228.3	703.8	547.0	156.8	77.7
210205	Эрүүл мэндийн даатгал	2,455.0	2,239.8	215.2	91.2	2,814.5	2,187.9	626.6	77.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	647.0	450.0	197.0	69.6	4,607.7	2,857.2	1,750.5	62.0
210303	Цэвэр, бохир ус	647.0	450.0	197.0	69.6	1,750.5	-	1,750.5	-
210302	Түлш, халаалт					1,282.2	1,282.2	-	100.0
210303	Цэвэр, бохир ус					1,575.0	1,575.0	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	12,456.0	10,980.3	1,475.7	88.2	7,567.8	8,952.8	(1,384.8)	118.3
210401	Бичиг хэрэг	780.0	780.0	-	100.0	945.0	945.0	-	100.0
210402	Тээвэр, цагахуун	10,636.0	9,360.3	1,475.7	86.4	5,752.8	7,137.6	(1,384.8)	124.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	360.0	360.0	-	100.0	495.0	495.0	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	480.0	480.0	-	100.0	375.0	375.0	-	100.0
2105	Норматив зардал	2,000.0	-	-	-	3,185.0	-	3,185.0	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000.0	-	-	-	3,185.0	-	3,185.0	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,740.0	15,539.0	201.0	98.7	10,717.2	10,717.2	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,035.0	(2,035.0)		5,717.2	5,717.2	-	100.0
210604	Урсгал засвар	15,740.0	13,504.0	2,236.0	85.8	5,000.0	5,000.0	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	1,900.0	1,704.0	196.0	89.7	1,000.0	860.0	140.0	86.0
210702	Дотоод албан томилолт	1,900.0	1,704.0	196.0	89.7	1,000.0	860.0	140.0	86.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,220.0	2,400.0	820.0	74.5	889.8	289.8	600.0	32.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,400.0	2,400.0	-	100.0	108.0	-	108.0	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400.0	-			214.2	131.8	82.4	61.5
210803	Даатгалын үйлчилгээ	140.0	-			179.7	95.0	64.7	62.9

210804	Тээврийн хэрэгслийн татаар	140.0	-	-	-	63.9	63.0	0.9	98.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	140.0	-	-	-	324.0	-	324.0	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,573.0	3,375.0	198.0	94.5	2,650.0	750.0	1,900.0	28.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,573.0	3,375.0	198.0	94.5	2,650.0	750.0	1,900.0	28.3
III	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	176,725.1	158,384.7	18,340.4	89.6	143,306.6	96,254.4	47,052.2	67.2

2025 онд 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2025 оны 3-р дугаар улирлын байдлаар 143,306.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 67.2хувь буюу 96,254.4 мянган төгрөгийг зарцуулж, 32.8 хувь буюу 47,052.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна

Урсгал зардлын гүйцэтгэлийг ангиллаар нь харьцуулбал: цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлаас 28,844.8 мянган төгрөгийн, ажил олгогчийн НДШ-ийн зардлаас 2,608.8 мянган төгрөгийн, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 1,750.5 мянган төгрөгийн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 600.0 мянган төгрөгийн, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлаас 1,900.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй буюу хэмнэлттэй зарцуулсантай холбоотой байна.

2.3. Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт олголтын байдал цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал:

Сэлэнгэ аймаг Цагааннуур сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12-р сарын 18 өдрийн 112 тогтоолоор Сэлэнгэ бүсийн сум дундын Ойн ангийн бүтэц орон тоог 5 орон тоотойгоор баталсан байна.

Сэлэнгэ бүсийн сум дундын ойн ангийн даргын тушаал 2025 оны 01-р дүгээр сарын 02 өдөр Б/01 тушаалаар албан хаагчдын цалин шинэчлэн тогтоосон байна.

2024 онд албанд ажиллагсдын орон тоо, цалин хөлс, нэмэгдэл, ажил олгогчоос төлөх НДШ-ийн батлагдсан төсөв, гүйцэтгэлд тулган баталгаажуулалт хийхэд цалингийн зардлыг 11,600.5 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 1,652.1 мянган төгрөгийн мянган төгрөгийн үлдэгдэлтэй буюу 9,5 хувь хэмнэлттэй байгаа нь батлагдсан бүтэц орон тоогоор ажиллаагүйтэй холбоотой байна.

Цалингийн гүйцэтгэлийг доорх хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	2024 оны жилийн эцэс		хэтрэлт хэмнэлт	Биелэлт хувь	2025 оны 3 дугаар улирал		хэтрэлт хэмнэлт	Биелэлт хувь
		Батлагдсан Төсөв	гүйцэтгэл			Батлагдсан Төсөв	гүйцэтгэл		

II	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ НИЙ ЗАРДАЛ	137,189.1	123,936.4	13,252.7	90.0	142,163.6	113,001.7	29,161.9	78.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	121,475.6	109,875.1	11,600.5	90.5	140,746.0	111,901.2	28,844.8	79.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,713.5	14,061.4	1,652.2	89.5	1,407.6	1,100.5	307.1	78.2

Сэлэнгэ аймаг Цагааннуур сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12-р дугаар сарын 30 өдрийн 22 тогтоолоор Сэлэнгэ бүсийн сум дундын Ойн ангийн бүтэц орон тоог 5 орон тоотойгоор баталсан байна.

Сэлэнгэ бүсийн сум дундын ойн ангийн даргын тушаал 2025 оны 01-р дүгээр сарын 02 өдөр Б/01 тушаалаар албан хаагчдын цалин шинэчлэн тогтоосон байна.

2025 оны 3-р дугаар улирлын байдлаараа албанд ажиллагсдын орон тоо, цалин хөлс, нэмэгдэл, ажил олгогчоос төлөх НДШ-ийн батлагдсан төсөв, гүйцэтгэлд тулган баталгаажуулалт хийхэд цалингийн зардлыг 28,844.8 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 2,608.8 мянган төгрөгийн мянган төгрөгийн үлдэгдэлтэй буюу 20,5 хувь хэмнэлттэй байгаа нь батлагдсан бүтэц орон тоогоор ажиллаагүйтэй холбоотой байна.

Цалин хөлсний тогтоолт, тооцоололтыг тулган баталгаажуулахад: Ажиллагсдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдлыг хяналт шалгалтын явцад цалингийн дэлгэрэнгүй цэсээс хүн тус бүрийн албан тушаалын ангилал, зэрэглэл, батлагдсан цагийн тооцоо, нэмэгдэл суутгал, тооцох тушаал шийдвэртэй тулган баталгаажуулахын зэрэгцээ НДШ-ийн дэлгэрэнгүй НД8 тайлантай нэг бүрчлэн тулган шалгахад илүү болон дутуу тооцоолж олгосон нөхцөл байдал илрээгүй болно.

Нэмэлт санхүүжилтийн дансанд:

2024 онд нэмэлт санхүүжилтийн нь дансанд нь 100130713402 төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын 10,034.4 мянган төгрөг бүрдүүлсэн. Үүнээс Цалин хөлс болон нэмэгдэл урамшил 3,982.5 мянган төгрөгийг Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 457,9 мянган төгрөгийг хангамж бараа материалын, зардалд 1,924.5 мянган төгрөгийн хүнсний зардалд 1,500.0 мянган төгрөгийг Бараа үйлчилгээний бусад зардалд 2,169.4 мянган төгрөгийн тус тус шилжүүлсэн нь зориулалтын дагуу зарцуулсан байна.

2025 оны 3-р дугаар улирлын байдлаараа нэмэлт санхүүжилтийн нь дансанд нь 100130713402 төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын 1,184.2 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна. хангамж бараа материалын, зардалд 723,0 мянган төгрөгийн зарлагын шилжүүлсэн нь зориулалтын дагуу зарцуулсан байна.

2.4. Хүний нөөцийн сонгон шалгаруулалт албан тушаалын тодорхойлолтод заасан шалгуур хангасан эсэх

2024 онд Ойн инженерийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт зарласан дагуу ойн инженерийн мэргэжилтэй 1 хүн бүртгүүлсэн байна., албан тушаалын тодорхойлолтод шаардлага хангасан Ойн инженерийн мэргэжилтэй, мэргэжлийн ур чадварын шалгалтыг тестээр болон ярилцлагын шалгалт авч дүгнэж албан тушаалд томилсон байна.

2.5 Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

2024-2025 онуудад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг хүртэл хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авалт хийдээгүй байна

2.6 Авлага, өр төлбөрийг баталгаажуулж , данс бүртгэлд бүрэн тусгасан эсэх

Хяналт шалгалтын хугацаанд тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаагаа зохион байгуулалттай, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, орлого зарлагын тэнцвэрийг ханган ажилласны үр дүнд аливаа өр, авлага үүсгэлгүй, санхүүгийн сахилга бат, хариуцлагыг бүрэн ханган ажилласан байна.

2.7 Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал

Сэлэнгэ бүсийн ойн ангийн санхүүгийн тайлангийн аудитыг Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар түүвэр хамруулж шалгасан бөгөөд санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой илэрсэн зөрчил өгөгдсөн зөвлөмж байхгүй байна.

2.8 Өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт

Сэлэнгэ бүсийн ойн анги нь 2024 оны эхэнд 245,285.4 мянган төгрөгийн /анхны үнээр/ хөрөнгийн үлдэгдэлтэй байснаас тайлант онд 6,170.0 хөрөнгө худалдан авсан, бөгөөд машин тоног төхөөрөмж 11,907.5 мянган төгрөгийн ахуйн эд хогшил 4,180.4 мянган төгрөгийн өртөгтэй нийт 16,087.,9 мянган төгрөгийн актлагдсан бөгөөд 236,367,5. мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2025 оны эхний хагас жилийн байдлаар 236,367.5 мянган төгрөгийн /анхны үнээр/ хөрөнгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байснаас тайлант улиралд 5,717.2 хөрөнгө худалдан авсан, бөгөөд машин тоног төхөөрөмж 2,300.0 мянган төгрөгийн ахуйн эд хогшил 360.0 мянган төгрөгийн,бусад үндсэн 666.6 мянган төгрөгийн хөрөнгө өртөгтэй нийт 3,326.6 мянган төгрөгийн актлагдсан бөгөөд 238,758.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үндсэн хөрөнгийн данс бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийг хөтлөх заавар аргачлал, бодлогын баримт бичигт тусгасан арга зүйгээр

үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна. Үндсэн хөрөнгийн болон бараа материалын тооллогыг хагас бүтэн жилээр хийж эд хариуцагчийн картыг хөтөлж хэвшсэн байна.

Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг явцад ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийн жагсаалт гаргаж өмч хамгаалах зөвлөлд шилжүүлэн, акталж устгах, шилжүүлэх зэргээр холбогдох дээд газрын шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж, данс бүртгэлд тусгасан байна.

2024-2025 онд Өмч хамгаалах байнгын зөвлөл нь үндсэн хөрөнгө шинээр авч байгаа хөрөнгөд бүрэн бүтэн байдал чанарын шаардлага хангасан дээр 3 удаа хуралдсан байна. Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн ашиглах боломжгүй хөрөнгийн талаар 3 удаа хуралдаж, хугацаа дууссан хөрөнгийг буюу элэгдлээрээ өртөг нөхсөн хөрөнгийг актлах саналыг хурлын шийдвэр гаргасныг байгууллагын удирдлагууд танилцуулж ажилласан байна.

2.9 Гүйцэтгэх удирдлагын дотоод хяналт тогтолцоо төлөвшсөн эсэх.

2024онд Сэлэнгэ бүсийн сумдын ойн анги Бүсийн сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч цагдаагийн албатай хамтран хяналт шалгалтыг 3 удаа Иргэд, Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагуудад гүйцэтгэлийн шалгалтыг 30 удаа хийн мод бэлтгэх, тээвэрлэлтийн хяналтын явцын шалгалт хийсэн байна. 2025 оны 3-р дугаар улирлын байдлаараа орчны хяналтын улсын байцаагч, цагдаагийн албатай хамтран байгалийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх ажлын хүрээнд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт 4 удаа хийсэн. Ойн мэргэжлийн байгууллага болох Буян-Од ХХК-ны Түшиг сумын Ганцын даваа, Баяны хавтгай, Үст ам гэх газруудад хийж буй ойжуулалтын явц, үйл ажиллагаанд хяналт Сэлэнгэ бүсийн сум дундын ойн ангийн дарга Н.Амаржаргал, Түшиг сумын Байгаль Бүсийн сумдын Ойн мэргэжлийн байгууллагуудад Түшиг суманд 11 удаа, Цагааннуур суманд 9 удаа мод бэлтгэх талбай тусгаарлалт хийсэн талбайд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж зөвлөгөө өгч хамтран ажилласан байна.

2.10 Санхүүгийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлийг заавар аргачлалын дагуу бүрэн үнэн зөв хөтөлсөн эсэх

Сэлэнгэ бүсийн сум дундын ойн ангийн нь 2024-2025 оны 3-р дугаар улирлын байдлаарх санхүүгийн ажил гүйлгээг анхан шатны баримтаар баталгаажуулсан эсэхийг тулган баталгаажуулахад сэлбэг материалын 9,700.000 мянган төгрөгийн ажил гүйлгээг анхан шатны баримтын санхүүгийн тамга гарын үсэг дутуу бүртгэлээр тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." 13.5."Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар

баталгаажгаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан" Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт нөхөх заавар"

2.11 Төсөвт төвлөрүүлэх орлогын үндэслэлтэй төлөвлөж бүрэн төвлөрүүлсэн эсэх

Сэлэнгэ бүсийн сум дундын ойн анги нь Цагааннуур сумын ИТХ-ын 2023 оны тодотгосон төсөв батлах 12-р дугаар сарын 18 өдрийн 109 дүгээр тогтоолоор 221,512 мянган төгрөгөөр Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласан төлбөрийн орлогын 221,512.0 мянган төгрөгөөр баталсан. 2024 оны Ойгоос хэрэглээний мод, түлээ мод бэлтгэж ашигласны төлбөрийн орлого 94,003.0 мянган төгрөгөөр төсөв төвлөрүүлсэн буюу 43,8 хувьтай гүйцэтгэлтэй байна. Аймгийн ИТХ-аас мод бэлтгэх хуваарьт өөрчлөлт оруулан, бэлтгэх хэмжээг бууруулснаас шалтгаалан ойгоос хэрэглээний мод, түлээ мод бэлтгэж ашигласны төлбөрийн орлого 124,509 мянган төгрөгөөр тасарсан нь байна. Сэлэнгэ бүсийн сум дундын ойн анги нь Цагааннуур сумын ИТХ-ын 2024 оны тодотгосон төсөв батлах 12-р дугаар сарын 30 өдрийн 13 дүгээр тогтоолоор Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласан төлбөрийн орлогын 94,692.8 мянган төгрөгөөр баталсан. 2025 оны 3-р дугаар улирлын байдлаараа Ойгоос хэрэглээний мод, түлээ мод бэлтгэж ашигласны төлбөрийн орлого 68,664.7 мянган төгрөгөөр төсөв төвлөрүүлсэн буюу 72,5 хувьтай гүйцэтгэлтэй байна.

2.12 Аймгийн ИТХ-аар баталсан 2024-2025 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод, түлээ бэлтгэх хуваарийг батлах тухай тогтоолын хэрэгжилт

Ойн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь заалт, Сэлэнгэ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дугаар сарын 29-ний өдрийн 10 тоот 2025 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод, түлээ бэлтгэх хуваарийг батлах тухай тогтоол, Цагааннуур сум, Түшиг сумдын нутаг дэвсгэрээс 2025 онд ойгоос бэлтгэх хэрэглээний болон түлшний модны төрөл, хэмжээ, бэлтгэх газар, мэргэжлийн байгууллага хамтын эзэмшлийн ойн нөхөрлөл, иргэдэд олгох модны хэмжээг Цагааннуур сумын иргэдийн төлөөлөгчдийн 2024 оны 12 сарын 30 ний өдрийн №21 тоот, Түшиг сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 01 дугаар сарын 13-ны өдрийн № 17 тоот, Зүүнбүрэн сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 сарын 30-ний өдрийн № 53 тоот тус тус батлан мод бэлтгэх үйл ажиллагаатай холбоотой хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөн ажиллах, хэрэглээний зориулалтаар болон түлээний модны батлагдсан хуваарийн дагуу аж ахуй нэгж байгууллагын хүсэлтийн дагуу ойн мэргэжлийн байгууллага болон иргэдэд олгож байна.

Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

2024 он, 2025 оны 3-р дугаар улирлын төсөв, санхүүгийн болон үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн

төлөвлөлт, гүйцэтгэл, бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлт, анхан шатны баримтын бүрдүүлэлт зэргийг тулган шалгахад холбогдох хууль, журам, стандартын дагуу хөтлөн явуулж байгаа боловч тэдгээртэй холбоотой хуулийн тогтоомж зөрчих үйлдэл оршсоор байна. Үүнд:

Илрүүлэлт 1. Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврыг мөрдөөгүй, ажил гүйлгээ гарсныг нотолж бичгээр бүрдүүлсэн болон бусад нотолгоог түүнийг үйлдсэн зөвшөөрсөн, шалгаж авсан ажилтны гарын үсгээр баталгаажуулаагүй сэлбэг материалын 9,700.000 мянган төгрөгийн ажил бүртгэл, тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." 13.5."Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан" Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт нөхөх заавар"

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэл дутуу бүртгэл, тайланд тусгахгүй байх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:

4.1 Дүгнэлт:

4.1 Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Сэлэнгэ бүсийн сум дундын ойн ангийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр "Бага" эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

4.2 Шийдвэрлэлт:

Сэлэнгэ бүсийн сум дундын ойн ангийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт 9,700.0 мянган төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч авсан болно.

Шалгалтаар илэрсэн зөрчил нь холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус Сэлэнгэ бүсийн сум дундын ойн ангийн дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэлд тусгагдсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн тайланг нотлох баримтын хамт 2025 оны 12 дугаар сарын 31-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт албан бичгээр ирүүлэхийг дарга, нягтлан бодогч нарт нь хариуцуулав.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

ДОТООД АУДИТОР

Д.ВАНЧИГМАА

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ *Menchul* Т.МӨНХЗУЛ



ТАНИЛЦСАН:

СЭЛЭНГЭ БҮСИЙН СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН

ДАРГА

Н.АМАРЖАРГАЛ

НЯГТЛАН БОДОГЧ

Н.ЦОЛМОН

